

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянзүрх Шижир ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/020/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга Ч.Болд
Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.com

Аудиторын менежер Я.Алтанцэцэг
Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.com

Өлзийт Экаунт Аудит ХХК-ний Гүйцэтгэх Захирал Ч.Эрдэнэжав
Утас: 88117655 Цахим хаяг: auditulziit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/299
танай _____-ны № _____-т

БАЯНЗҮРХ ШИЖИР
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Л.ДАНЗАНРАВЖАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянзүрх Шижир ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 994.7 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Баянзүрх Шижир ОНӨААТҮГ-ын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл байдал үүсээгүй гэж үзсэн.

Аудитын гол асуудал

Тус газар нь хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай хамтран ажиллах гэрээ байгуулан, Нийслэлийн долоон дүүргээс 168 өндөр настан, долоон аймгаас 25 өндөр настанг тус тус хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн байна.

Бусад асуудал

Тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 189.3 сая төгрөг төлөвлөснөөс, 163.3 сая төгрөгийг зарцуулж, төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг 50.0 хувьтай хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	411,504.93	13,173.39
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	279,840.41	279,840.41
1.1.6	Бараа материал	16,938,267.68	17,912,442.19
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	17,629,613.02	17,912,442.19
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,069,119,176.93	976,843,222.59
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,069,119,176.93	976,843,222.59
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,086,748,789.95	995,048,678.58
2.1.1.1	Дансны өглөг	6,113,776.59	20,562,579.66
2.1.1.2	Цалингийн өглөг	5,437,451.82	22,477,576.35
2.1.1.3	Татварын өр	17,866,672.96	21,595,546.78
2.1.1.4	НДШ-ийн өглөг	3,713,738.82	21,073,933.43
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,045,128,180.20	1,045,128,180.20
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,078,259,820.39	1,130,837,816.42
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,078,259,820.39	1,130,837,816.42
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	91,461,287.78	91,461,287.78
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(82,972,318.22)	(227,250,425.62)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	8,488,969.56	(135,789,137.84)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,086,748,789.95	995,048,678.58

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	110,197,454.55	19,094,495.45
3	Нийт ашиг(алдагдал)	110,197,454.55	19,094,495.45
9	Борлуулалт, маркетингийн зардал	227,882,285.50	157,933,268.14
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,955,297.66	394,527.28
11	Санхүүгийн зардал		34,800.00
12	Бусад зардал		5,010,100.00
12.1	Зардлын дүн	229,837,583.16	163,372,695.42
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(119,640,128.62)	(144,278,199.97)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(119,640,128.62)	(144,278,199.97)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(119,640,128.62)	(144,278,199.97)
24	Орлогын нийт дүн	(119,640,128.62)	(144,278,199.97)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	91,461,287.78	36,667,810.40	128,129,098.18
Залруулсан үлдэгдэл	-	91,461,287.78	36,667,810.40	128,129,098.18
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(119,640,128.62)	(119,640,128.62)
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	91,461,287.78	(82,972,318.22)	8,488,969.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	-	92.57	92.57
Залруулсан үлдэгдэл	-	91,461,287.78	(82,972,225.65)	8,489,062.13
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(144,278,199.97)	(144,278,199.97)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	91,461,287.78	(227,250,425.62)	(135,789,137.84)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	112,077,200.00	21,003,945.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	112,077,200.00	21,003,945.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	112,653,451.69	40,831,172.18
1.2.1	Ажиллагчдад төлсөн	45,393,147.00	15,663,968.18
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	12,400,00.00	-
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	33,665,198.05	12,363,524.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,481,579.31	8,545,037.69
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,792,462.00	1,876,002.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,021,867.07	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	9,899,198.26	2,382,640.31
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(576,251.69)	(19,827,227.18)
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,030,000.00	-
2.3	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,030,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,030,000.00)	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,817,474.66	28,378,803.07
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	6,817,474.66	28,378,803.07
3.2	Мөнгөн зарлагын дүн (+)	2,400,000.00	8,950,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,400,000.00	8,950,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,417,474.66	19,428,803.07
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(188,777.03)	(398,424.11)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	600,281.96	411,597.50
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	411,504.93	13,173.39

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1.Нийт орлого	118,894,674.66	96,000,000.00	19,094,495.45	(76,905,504.55)	19.9
Үйл ажиллагааны бусад орлого	118,894,674.66	96,000,000.00	19,094,495.45	(76,905,504.55)	19.9
2.Нийт зардал	115,053,359.12	189,438,400.00	163,372,695.42	(26,065,704.58)	86.3
Үндсэн цалин	45,393,147.00	140,160,000.00	38,793,828.00	(101,366,172.00)	2.8
Нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,400,000.00	16,328,400.00	4,662,384.39	(11,666,015.61)	28.6
Шатахуун	4,792,462.00	2,400,000.00	760,001.81	(1,639,998.19)	31.7
Хангамжийн материал	33,665,198.05	-	6,396,817.37	(6,396,817.37)	100.0
Цахилгаан	4,481,579.31	11,350,000.00	8,548,337.69	(2,801,662.31)	75.3
Халаалт дулаан	-	15,000,000.00	-	15,000,000.00	100.0
Харилцаа холбоо	-	1,200,000.00	-	1,200,000.00	100.0
Засвар үйлчилгээ	-	-	438,963.64	(438,963.64)	(100.0)
Татварын байгууллагын төлбөр	2,021,867.07	-	-	-	-
Биет ба биет бус хөр худ авсан зардал	4,030,000.00	-	-	-	-
Ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	1,881,944.52	(1,881,944.55)	(100.0)
Үйл ажиллагааны бусад	12,299,105.69	3,000,000.00	101,890,418.00	(98,890,417.97)	(0.0)
3.Ашиг алдагдал	(88,684.46)	(93,438,400.00)	(144,278,199.97)	-	-

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Бараа материалыг тоолж баталгаажуулаагүй	1	17,873.4			1	17,873.4								
2	Үндсэн хөрөнгийг тоолж баталгаажуулаагүй	1	976,843.2			1	976,843.2								
3	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн "анхны хөрөнгө оруулалтыг хувь нийлүүлсэн хөрөнгө дансанд бүртгэх " зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-			1	-								
	Дүн	3	994,716.6			3	994,716.6								

6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны нэгдсэн цахим системд батлагдсан зорилтод түвшин, санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийг байршуулаагүй байна.	1	-			1	-
Дүн	1	-			1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Батлагдсан зорилтот түшингээс орлогыг 118,094.9 мянган төгрөгөөр дутуу, зардлыг 57,308.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.	1	175,402.9			1	175,402.9
	1	175,402.9	1	-	1	175,402.9
Нийт дүн	2	175,402.9	1	-	2	175,402.9